



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/615

Номгон

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
улсын үзлэг зохион байгуулах ажлын хэсэг
томилох тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/8 тоот “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” тогтоолын 28 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын үзлэгийг Эрчим хүчний салбарт 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны хооронд зохион байгуулсугай.

2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн улсын үзлэгийг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Д.Энхжаргал- Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн дарга

Гишүүд М.Мөнхбат-Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч

Л.Намжилмаа -Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч

П.Уранчимэг -Хөдөлмөрийн хяналтын олон нийтийн улсын байцаагч

Нарийн бичгийн дарга Э.Лхагвадулам- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн


601210439

2.

3. Үзлэг хийхэд шаардагдах 283,200 (Хоёр зуун наян гурван мянга хоёр зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4. Үзлэгийг үр дүнтэй байдлаар хийх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үзлэгийн үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж, дүгнэлт, саналын хамт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Д.Энхжаргалд)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН